



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН
ХОЛБООНЫ ЭВЛЭРҮҮЛЭН
ЗУУЧЛАЛЫГ ДЭМЖИХ ХОРОО

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ 2023-2025 ОНЫ ТАЙЛАН

Эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн онол, практикийг судлах, эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр ажилладаг хуульчдын мэргэжлийн арга барил, дадлага туршлагыг харилцан солилцох чиглэлээр мэргэжиж ажиллах сонирхол бүхий хуульчид сайн дураараа нэгдэн Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хороог байгуулж, Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 38 тоот тогтоолоор батламжлуулсан байдаг. Тус хороо нь хорооны дүрэмд заасан зорилго, зорилтуудыг биелүүлэх, Монголын Хуульчдын холбооны явуулж буй эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр зохион байгуулах бүхий л үйл ажиллагааг дэмжин оролцох, хорооны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, гишүүдийнхээ идэвхи санаачилга, оролцоог нэмэгдүүлэх зорилтуудыг өмнөө тавьж ажиллаж байна.

Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хороо нь 2023 онд 170 гишүүн, 2024 онд 181 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2025 онд гишүүдийнхээ тоог нэмэгдүүлэх, мэдээллийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, гишүүдийн тоогоо 213 болж нэмэгдсэн байна.




Удирдах зөвлөлийн гишүүдийг идэвхжүүлэх, гишүүдийг нөхөн сонгох ажлуудыг тухай бүр хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2025 оны байдлаар тус хорооны Тэргүүнээр Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Амарсанаа, Ж.Сайнхишиг, Э.Цолмон Э.Одонтуяа, Д.Уянга, Г.Халиун, М.Сэлэнгэ, З.Тунгалагмаа, Г.Энхтуяа нарын ажиллаж байна.



Хорооны Удирдах зөвлөлийн хурал:

Хороо нь 2023 онд 4, 2024 онд 4, 2025 онд 5 нийт 13 удаа хуралджээ.

Удирдах зөвлөлийн хурлын тоон мэдээ



Санамж бичиг:

- ШЕЗ-ийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлтэй хамтран ажиллах, сургагч багш бэлтгэх, эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхижуулах, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр өргөн хүрээнд хамтран ажиллахаар санамж бичиг байгуулав.




- Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагатай “Монгол улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг

бэхжүүлэх нь” төслийн гол зорилгыг хэрэгжүүлэх, харилцан санал солилцох, зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхижуулах, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр хамтран ажиллахаар санамж байгуулав.



- Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитртай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зураг ажлыг санаачлан хэрэгжүүлэв.



Өглөөний уулзалт:

- “Эвлэрүүлэн зуучлалын хууль хэрэгжсэний сайн туршлага ба ололт амжилт”
- “Эвлэрүүлэн зуучлал ба нотариатын оролцоо” сэдэвт
- “Хөдөлмөрийн харилцаан дахь Эвлэрүүлэн зуучлал”
- “Эвлэрүүлэн зуучлалын Олон Улсын туршлага”

Сургалт:

- Эвлэрүүлэн зуучлагчдын чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх сургалт
- “Арилжааны эвлэрүүлэн зуучлалын чиглэлд эвлэрүүлэн зуучлагчдын чадавхыг бэхжүүлэх” сургалт
- 'Why mediation?, Why for businesses?'

Подкаст:

- “Эвлэрүүлэн зуучлалын тухай ойлголт” сэдэвт подкаст
- “Монгол улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх төслийн онцлог, үр дүн” сэдэвт подкаст
- “Эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар” сэдэвт подкаст
- “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эргэн тойронд” сэдэвт подкаст

Хэлэлцүүлэг:

- “Эвлэрүүлэн зуучлалын үр нөлөө ба цаашид анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг
- “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал” сэдэвт хэлэлцүүлэг
- “Монгол, Сингапурын Эвлэрүүлэн зуучлалын харьцуулалт, ялгаатай байдал” сэдэвт хэлэлцүүлэг
- “Why mediation? Арилжааны эвлэрүүлэн зуучлалын талаарх канад улсын сайн туршлага” сэдэвт чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг
- 'Why mediation? Why for Lawyers?' сэдэвт сургалт, хэлэлцүүлэг



Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөлд санал өгөв:



Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулж, Монголын Хуульчдын холбооноос өгөх саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэв.

Гишүүдийн нээлттэй өдөрлөг анх удаа зохион байгуулав:

Хорооноос гишүүдээ идэвхжүүлэх, хорооны үйл ажиллагааг таниулах зорилгоор нийт гишүүдийнхээ дунд нээлттэй өдөрлөгийг анх удаа зохион байгуулав.



Арилжааны эвлэрүүлэн зуучлал” гарын авлага хэвлүүлэв:

Европын холбооны санхүүжилтээр Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас “Монгол Улсад Арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь (2023-2025) төслийн төслийн хүрээнд “Арилжааны эвлэрүүлэн зуучлал” гарын авлагыг боловсруулахад Монголын Хуульчдын холбоо нь хамтран ажилласан бөгөөд холбооны Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны тэргүүн Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн З.Тунгалагмаа нар оролцов.




Хуульчдад эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хэрэгжүүлж байхыг уриалав:



Эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх нь талуудын цаашдын хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх, найрсаг харилцааг хадгалж үлдэх зэрэг тал бүрийн ач холбогдолтой. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлохдоо 24.1.4-д “нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах” хэмээн хуульчилж өгсөн байдаг. Иймд хуульчдыг эвлэрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд, чадварлаг хэрэгжүүлж байхыг уриалав.

Гишүүдээ мэдээллээр хангах ажлыг идэвхжүүлэв:

Хорооны гишүүдэд Холбоо болон Хорооны мэдээллийг түргэн шуурхай хүргэх хүрээнд фэйсбүүк хуудас, хаалттай групп нээн удирдаж, мэдээллээ тогтмол нийтэлж байна.



Хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын хөтөлбөрийг магадлан итгэмжлэв:

Хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын сургалтын хөтөлбөрийг орчин үеийн сургалтын арга зүй, хэлбэр, шаардлагад тулгуурлан видео болон танхимын хэлбэрээр боловсруулж, магадлан итгэмжлүүлэхээр Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороонд хүргүүлэв.

Бусад:

Эвлэрүүлэн зуулалыг дэмжих хорооны Удирдах зөвлөлийн гишүүд болон хорооны гишүүд нь Хуульчдын холбооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй орж ажиллаж байна.

